


2022.08.03




# 2022 оны эхний хагас жилийн үр дүн

*"Инвескор ББСБ" ХК*

*Нэгтгэсэн тайлан*



# ГРУППИЙН БҮТЭЦ



# ӨРСӨЛДӨӨНИЙ ДАВУУ ТАЛУУД

## ТӨВ АЗИЙН ЗАХ ЗЭЭЛ

- Урт хугацааны тогтвортой өсөлтийн үндэс суурь болох Төв Азийн зах зээлийн тэлэлт



Санхүүгийн экспорт

## УЛАМЖЛАЛТ БОЛОН ФИНТЕК БҮТЭЭГДЭХҮҮН

- Үйл ажиллагааны зардлыг бууруулж, хүүгийн бус орлогыг нэмэгдүүлэх Финтек бүтээгдэхүүн, бизнес загвар



Экосистем

## ТӨРӨЛЖСӨН САНХҮҮЖИЛТЫН ЭХ ҮҮСВЭР


- Хөрөнгийн бирж дээр нээлттэй бонд, хувьцаа гаргах, хөрөнгө босгох үйл ажиллагаа
- Хөгжлийн санхүүжилтын байгууллагуудын хөрөнгө оруулалт



ЖДҮ эрхлэгчдэд хүртээмжтэй санхүүжилт



# ХУВЬЦААНЫ ХАНШ



**Гаргасан хувьцааны тоо** **71,727,918**

Зарласан хувьцааны тоо 82,000,000

P/E харьцаа (2022.06.30) 11.7

P/B харьцаа (2022.06.30) 3.5

EPS (2022.06.30) 372.2 төг

Хувьцааны ханш:

4349₮

2022.Н1 жилийн өсөлт:

40%



IPO-с хойш:

164%



- ✓ 2019 онд анх удаа олон нийтэд хувьцаагаа санал болгож, 18.6 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.
- ✓ Топ 20 индекст багтаж, Монголын хөрөнгийн биржийн 1 дүгээр самбарт жагсаж амжилт гаргасан.
- ✓ 2022 оны эхний хагас жилийн байдлаар хувьцааны үнэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 40%-иар өсч, 4349 төгрөгт хүрсэн.
- ✓ IPO-оос хойших өсөлтийн хувь : **164%**
- ✓ Зах зээлийн үнэлгээ: **312 тэрбум төгрөг** (ойролцоогоор 100 сая доллар)



# НЭМЭЛТ ХУВЬЦАА-FPO



“Инвекор ББСБ” ХК нь 4,016,363 ширхэг нэмэлт хувьцаагаа тус бүр нь 4,155 төгрөгийн үнээр олон нийтэд санал болгож 100.4 хувийн амжилттайгаар татан төвлөрүүллээ. Ингэснээр компанийн олон нийтийн эзэмшлийн хувь 19.51% болж нэмэгдсэн байна.

## Нэмэлт хувьцаа гаргаснаар өөрчлөлт орсон эзэмшлийн бүтэц

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
“Эс Ай Би Жэй Капитал” ХХК	60,968,730	80.49%
Олон нийт	14,775,551	19.51%
<b>Нийт</b>	<b>75,744,281</b>	<b>100.00%</b>



# 2022 ОНЫ ГОЛ АМЖИЛТУУД

- ✓ Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 болон Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 27001 олон улсын стандартуудыг амжилттай нэвтрүүлсэн.
- ✓ 2021 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 25 төгрөг буюу нийт 1.8 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд тараасан.
- ✓ “Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн Монгол улсын эдийн засгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хүрээнд бизнес эрхлэгчдэд 1 сая долларын хөнгөлөлттэй зээл олгосон.
- ✓ Нидерланд улсын Краудфандинг платформ болох “Hands-on B.V.” компаниас 2.5 сая ам.доллар татах хэлэлцээр хийсэн.
- ✓ “Покет КГ” ХХК нь Киргиз улсын төв банкнаас төлбөрийн системийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлөө авсан.
- ✓ Шинэ зах зээлд нэвтрэх хүрээнд Казакстан улсад охин компани байгуулсан.



lendahand 




RioTinto





# СУВГИЙН МЕНЕЖМЕНТ



- ✓ Компани 2022 оны эхний хагас жилийн байдлаар 18 салбартай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Улаанбаатар хотод 16, Эрдэнэт хотод 1 салбар тус тус байрлаж, 1 салбарын үйл ажиллагаа бүрэн цахимаар явагдаж байна.
- ✓ Зээлийн ажилтнууд компанийн болон хэрэглэгчдийн цагийг хэмнэхийн тулд үйл ажиллагаанд таблет ашиглах үйл ажиллагааг эхлүүлж байна.
- ✓ Компани олон улсын зах зээлд тэлэх стратегийн хүрээнд Киргизстан улсад 2 охин компани ("Инвескор Си Эй" МФК, "Покет КГ" ХХК) , Казакстан улсад 1 охин компани ("Инвескор КЗ" ХХК) тус тус байгуулаад байна.
- ✓ 2022 оны эхний хагас жилийн байдлаар, охин компани болох "Инвескор Си Эй" МФК нь Киргизстан улсад 4 салбартай үйл ажиллагаагаа явуулж байна.



# ПОКЕТ ЦАХИМ ХЭТЭВЧ, ЦАХИМ ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



## Гол давуу талууд:

- 65 үндсэн ажилтан, 3 салбартай
- SISA олон улсын байгууллагаас "PCI DSS-д бүрэн нийцсэн" болохыг баталгаажуулж гэрчилгээ олгосон
- "Маркетплейс" цахим зээлийн төвөөр дамжуулан бусад санхүүгийн байгууллагууд өөрийн хэрэглэгч нартаа цахим зээлийн бүтээгдэхүүнээ санал болгож байна.





# “ИНВЕСКОР СИ ЭЙ” МФК

- ✓ Киргиз Улсын зах зээлд “Золотой Стандарт МКК” ХХК нэрээр үйл ажиллагаа явуулж байсан бичил зээлийн байгууллагыг “Инвескор ББСБ” ХК 2019 онд худалдан авч эзэмшсэн бөгөөд 2021 онд **Бичил санхүүгийн компанийн** тусгай зөвшөөрөл авсан.
- ✓ “Инвескор ББСБ” ХК нь өөрийн үйл ажиллагааны журам, процесс, систем болон нөү-хау зэргийг уг байгууллагад бүрэн нэвтрүүлж зах зээлд дахин байршуулалтыг амжилттай хийсэн болно.
- ✓ Киргиз дэх охин компани нь хөдөө аж ахуй, худалдаа, аж үйлдвэрлэлийн салбар дахь дотоодын бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр түлхүү ажиллаж байна.
- ✓ 2022.06.30 байдлаарх гол санхүүгийн үр дүн, үзүүлэлтүүд:

Үндсэн ажилтны тоо: 30

Салбарын тоо: 4


**Нийт зээлийн багц 11 тэрбум төгрөг**, өмнөх оны мөн үеэс 137%-иар өссөн.

Нийт хөрөнгө 12.8 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 173%-иар өссөн.

Нийт зээлийн тоо 941-т хүрч өмнөх оны мөн үеэс 72%-иар өссөн.



# ИНВЕСКОР АЛЛИАНС ХӨТӨЛБӨР



- ✓ “Инвескор ББСБ” ХК нь ухаалаг тэлэлт стратегийн хүрээнд орон нутгийн ББСБ-уудтай өрсөлдөх бус хамтран ажиллах зорилгоор Инвескор Алианс хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- ✓ “Инвескор ББС”Б ХК нь гишүүн ББСБ-уудтай доорх чиглэлээр дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
  - Санхүүгийн эх үүсвэр (зээлийн шугам)
  - Бүртгэлийн системүүд
  - ЖДБ-г дэмжих зээл, зөвлөх үйлчилгээ
  - Дүрэм журам, процесс зураглал

- ✓ Алианс хөтөлбөр нь Өмнөговь, Өвөрхангай, Дорнод аймагт нийт 4 гишүүнтэй байна.
- ✓ 2022 оны эхний хагас жилийн байдлаар Гишүүн ББСБ-ууд 1004 харилцагчийн 2.6 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байна.
- ✓ 2022 оны 2-р хагаст шинээр 6 аймагт гишүүн элсүүлэхээр ажиллаж байна.




# ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР /нөхцөл/

RioTinto

“Рио Тинто Монгол” ХХК нь 1 сая ам.долларын санхүүжилт бүхий ковидын хүндрэлийг даван туулах, эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн хэрэгжүүлэгчээр “Инвескор ББСБ” ХК-ийг сонгон хамтран ажиллаж байна.

<b>Хугацаа</b>	<b>24 сар хүртэл</b>
<b>Дүн</b>	30 сая төгрөг хүртэл
<b>Жилийн хүү</b>	4.8% (төгрөгийн)
<b>Барьцаа</b>	Зээлийн үнийн дүнгийн 60-аас доошгүй хувь нь биет хөрөнгө байна
<b>Зорилтот групп</b>	<ul style="list-style-type: none"><li>• Өрх толгойлсон ЖДҮ эрхлэгч</li><li>• Эмэгтэй ЖДҮ эрхлэгч</li><li>• Хөгжлийн бэрхшээлтэй ЖДҮ эрхлэгч</li><li>• Импортыг орлох ЖДҮ эрхлэгч</li><li>• Байгаль орчинд ээлтэй төсөл хэрэгжүүлэгч ЖДҮ эрхлэгч</li></ul>
<b>Бусад</b>	Зээлийн хүүгийн орлого зээлдэгчид зөвлөгөө өгөх, сургалтын хөтөлбөрөөр хангахад бүрэн зарцуулагдана.



# ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР /үр дүн/

RioTinto

## RioTinto

**152+**

*Зээл олгосон ААН, иргэн*


**2280+**

*Нөлөөлөл үзүүлсэн*

**500+**

*Ажлын байр хадгалсан*

Монголын Тогтвортой Санхүүжилтын Корпорациас гаргасан Байгаль орчин, нийгмийн засаглалын зарчимд нийцсэн.



## Зээлийн багц

**49%**

*Импортыг орлох  
бүтээгдэхүүн*

**41%**

*Эмэгтэй бизнес эрхлэгч*


**6%**

*Хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгч, өрх  
толгойлсон эцэг/эхийн бизнес, байгальд  
ээлтэй бизнес эрхлэгч*



# ЗЭЭЛИЙН БАГЦ /НЭГТГЭСЭН/


Зээлийн багц, харилцагчдын тоо



## 2022 оны эхний хагас жилийн үр дүн

- ✓ Нийт зээлийн багц өмнөх оны мөн үетэй харьцуулахад 108%-р өсч, 253 тэрбум төгрөгт хүрсэн.
- ✓ Зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 120%-иар өсч, 116,101-д хүрсэн.
- ✓ Нэг зээлдэгчид ногдох зээлийн дундаж хэмжээ 2.2 сая төгрөг

Зээл олголт, эргэн төлөлт (сая төг)




- ✓ Зээлийн олголт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 142%-р, эргэн төлөлт 130%-р тус тус нэмэгдсэн байна.
- ✓ 2022 оны сүүлийн хагас жилд бизнесийн зээлийн олголтыг илүү нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.



# ЗЭЭЛИЙН БАГЦ /НЭГТГЭСЭН/


Зээлийн багц, бүтээгдэхүүнээр (Н1 2022)

■ Бизнесийн зээл ■ Автомашины зээл ■ Хэрэглээний зээл ■ Дижитал зээл



✓ Бизнесийн харилцагч нарт бид зөвхөн санхүүжилт олгохоос гадна сургалт, зөвлөх үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж, харилцагчаа дэмжиж ажилласаар ирсэн.

Зээлийн багцын чанар




✓ “Инвескор ББСБ” ХК-ийн зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь санхүүгийн секторын хэмжээнд бага түвшинд байна.






# САНХҮҮГИЙН ҮР ДҮН /нэгтгэсэн/

Нийт хөрөнгө (сая төг)



Эздийн өмч (сая төг)



2022.06.30 байдлаар:

Нийт хөрөнгө: 289 тэрбум төгрөг

Эздийн өмч: 89 тэрбум төгрөг

Жилийн өмнөхтэй харьцуулахад:


Нийт хөрөнгө 85%-иар өссөн

Эздийн өмч 51%-иар өссөн




# САНХҮҮГИЙН ҮР ДҮН /нэгтгэсэн/

Хүү, шимтгэлийн орлого (сая төг)



Цэвэр ашиг (сая төг)



2022.06.30 байдлаар:

Хүү, шимтгэлийн орлого: 41 тэрбум төгрөг

Цэвэр ашиг: 15 тэрбум төгрөг

Жилийн өмнөхтэй харьцуулахад:

Хүү, шимтгэлийн орлого 115%-иар өссөн

Цэвэр ашиг 103%-иар өссөн

